

“Ой тэмдэглэх тухай”

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд Ерөнхийлөгчийн ивлээл дор “Ой тэмдэглэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Баттулгаас ирүүлсэн холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчид:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жилийн ойг 2011 онд, Эзэнт Богд Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойг 2012 онд төрт ёсны их баяр болгон тэмдэглэн өнгөрүүлэхийг Засгийн газарт чиглэл болгох.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

Монгол Улсын хувьд түүхэн ач холбогдолтой дараах ойнуудыг улс, үндэстний хэмжээнд ёслон тэмдэглэж байх нь зүйтэй хэмээн үзэв. Үүнд:

1. Төв Азийн нүүдэлчдийн анхны төр улс Хүннү гүрэн байгуулагдсаны ой
2. Эзэн богд Чингис хааны мэндэлсний ой
3. Их Монгол Улсын ой
4. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой
5. 1921 оны Ардын хувьсгалын ой
6. Үндэсний их баяр наадам
7. Анхдугаар Үндсэн хуулийг баталж, Бүгд Найрамдах засаглал тогтоосон ой
8. 1990 оны Ардчилсан хувьсгалын ой

Эдгээр их ойнуудаас Ардын хувьсгалын ой буюу Үндэсний их баяр наадмыг жил бүр, бусад ойг 10 жил тутамд ёслон тэмдэглэж байх.

